

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/88/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас:51-261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас:51-260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Аудитор: М.Ганбаатар
Утас: 51- 261628 Цахим хаяг: ganbaatar.m@audit.gov.mn
Аккурэйт финанс аудит ХХК-ийн захирал: Ж.Оюунбилэг
Утас:70133743 Цахим хаяг: acc.fin.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	9
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	10
3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин	10
3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	11
3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал.....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт	16
5.2 Зөвлөмж.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АМГТГ	Ашигт малтмал газрын тосны газар
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТАСИС	Харилцан туслах орнуудын техникийн тусламж /Technical Assistance for the Commonwealth of Independent States/
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 06/716
танай _____-ны № _____-т

ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ
БАЙГУУЛАМЖ ТӨҮГ-ЫН
ЗАХИРАЛ Г.ГАНСҮХ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 146 дугаар тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг нэгдсэн удирдлагаар хангах, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн тоог бууруулах, ашиг орлогыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж төрийн өмчит үйлдвэрийн газрыг “Эрчис ойл” ТӨХХК-д нэгтгэхээр шийдвэрлэж, үйлдвэрийн газрын үл хөдлөх болон бусад эд хөрөнгийг зохих журмын дагуу балансаас баланст, орон тооны хамт шилжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгаснаар 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон Эрчис ойл ТӨХХК-д нэгтгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 513 дугаар тогтоолоор Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, 408 нэрийн, нийт 20,920.1 сая төгрөгийн балансын үнэ, 7,516.4 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий үндсэн хөрөнгийг Эрчис-Ойл ТӨХХК-д балансаас балансад шилжүүлэн өгсөн.

Мөн Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ нь кассан дахь бэлэн мөнгө болон харилцах данснуудын үлдэгдэл 2,108.9 сая, арилжааны 3 банкан дахь хадгаламж 9,199.4 сая төгрөг, нийт 11,308.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, 136.4 сая төгрөгийн бараа материал, авлагын дансанд бүртгэлтэй 599.0 сая төгрөг, татвар нийгмийн даатгалын авлага 9.5 сая төгрөг, бусад авлага 193.5 сая төгрөг, нийт 802.0 сая төгрөгийн авлага, урьдчилж төлсөн зардал дансанд бүртгэлтэй 11.7 сая төгрөг, шатахууны картын үлдэгдэл 4.1 сая төгрөг, өр төлбөр дансны 205.6 сая төгрөгийн үлдэгдлийг тус тус балансаас балансад шилжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

БНСУ-ын К-Петро компаниас зохион байгуулсан олон улсын чанартай ур чадварын хөтөлбөр болон Ашигт малтмал газрын тосны хэрэг эрхлэх газрын нэгдсэн лабораториудын холбооноос зохион байгуулсан лаборатори хоорондын харьцуулалтын ур чадварын хөтөлбөрт оролцож лабораторийн болон ажилчдын мэргэжилтний ур чадварын чадавхаа үнэлүүлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2024 оны 12-р сарын 31	2025 оны 10-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,583,513,804.42	-
1.1.2	Дансны авлага	707,809,747.40	-
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	3,014,224.22	-
1.1.4	Бусад авлага	307,609,824.39	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	6,080,877,606.75	-
1.1.6	Бараа материал	234,536,215.28	-
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	18,000,000.00	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	11,935,361,422.46	-
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		-
1.2.1	Үндсэн хөрөнгө	12,424,677,862.18	-
1.2.2	Биет бус хөрөнгө	1,293,450,876.46	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	85,259,842.85	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	13,803,388,581.49	-
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	25,738,750,003.95	-
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		-
2.1	Өр төлбөр		-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		-
2.1.1.1	Дансны өглөг	-	-
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	5,162,668.79	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	306,163,796.45	-
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	3,909,977.30	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	315,236,442.54	-
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	23,043,218.19	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	23,043,218.19	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	338,279,660.73	-
2.3	Эздийн өмч		-
2.3.1	Өмч:-төрийн	15,362,339,049.32	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	533,483,446.52	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	9,504,647,847.38	-
2.3.11	Эздийн өмчийн дүн	25,400,470,343.22	-
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	25,738,750,003.95	-

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/			
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 10-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	11,634,720,544.78	3,214,158,308.17
2	Борлуулалтын өртөг	7,454,824,160.09	-
3	Нийт ашиг(алдагдал)	4,179,896,384.69	3,214,158,308.17
5	Хүүгийн орлого	669,071,926.99	811,335,508.53
8	Бусад орлого	166,715,454.90	124,552,272.72
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,485,563,973.43	2,681,128,242.20
12	Бусад зардал	176,200.00	122,800.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз/гарз	-	(51,185,814.63)
17	Бусад ашиг/алдагдал	(141,504,777.35)	(111,549,352.29)
18	Татвар төлөхийн өмнө хашиг(алдагдал)	2,388,438,815.80	1,306,059,880.30
19	Орлогын татварын зардал	249,534,848.01	134,339,146.23
20	Татварын дараах ашиг (алдагдал)	2,138,903,967.79	1,171,720,734.07
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	2,138,903,967.79	1,171,720,734.07

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/					
Мөр	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	15,362,339,049.32	533,483,446.52	7,712,855,614.14	23,608,678,109.98
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	74,378.10	74,378.10
3	Залруулсан үлдэгдэл	15,362,339,049.32	533,483,446.52	7,712,929,992.24	23,608,752,488.08
	Зарласан ногдол ашиг	-	-	(347,186,112.65)	(347,186,112.65)
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	2,138,903,967.79	2,138,903,967.79
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	15,362,339,049.32	533,483,446.52	9,504,647,847.38	25,400,470,343.22
11	Залруулсан үлдэгдэл	15,362,339,049.32	533,483,446.52	9,504,647,847.38	25,400,470,343.22
13	Өмчид гарсан өөрчлөлт	(15,362,339,049.32)	(551,453,874.45)	(9,606,916,597.55)	(25,520,709,512.32)
14	Зарласан ногдол ашиг	-	-	1,069,451,983.90)	(1,069,451,983.90)
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	1,171,720,734.07	1,171,720,734.07
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	17,970,427.93	-	17,970,427.93
17	2025 оны 10-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	-	-

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12-р сарын 31	2025 оны 10-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	24,597,851,440.76	9,873,056,943.74
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	12,312,057,710.20	3,781,103,138.99
1.1.6	Бусад мөнгөн орлого	12,285,793,730.56	6,091,953,804.75
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	22,655,724,647.50	11,840,820,222.84
	Ажиллагчдад төлсөн	1,105,289,917.00	1,358,951,116.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	319,053,000.00	343,330,237.34
	Бараа материал худалдан авахад төлсөн	8,235,532,000.32	43,706,629.00
	Ашиглалтын зардалд төлсөн	76,076,692.46	49,129,773.90
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	54,193,210.00	138,394,265.00
	Татварын байгууллагад төлсөн	721,748,222.15	616,028,731.21
	Даатгалын төлбөрт төлсөн	118,800.00	4,957,200.00
	Бусад мөнгөн зарлага	12,143,712,805.57	9,286,322,270.39
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,942,126,793.26	(1,967,763,279.10)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	669,071,926.99	811,335,508.53
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
	Хүлээн авсан хүүний орлого	669,071,926.99	811,335,508.53
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	238,269,012.67	2,357,634,049.95
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	237,768,387.22	242,806,545.45
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	500,625.45	5,906,363.64
	Бусад мөнгөн зарлага	-	2,108,921,140.86
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	430,802,914.32	(1,546,298,541.42)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	347,186,112.65	1,069,451,983.90
3.2.4	Төлсөн ногдол ашиг	347,186,112.65	1,069,451,983.90
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(347,186,112.65)	(1,069,451,983.90)
4	Валютын ханшийн зөрүү	-	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,025,743,594.93	(4,583,513,804.42)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,557,770,209.49	4,583,513,804.42
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,583,513,804.42	-

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж төрийн өмчит үйлдвэрийн газрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/2025 гүйц	Хувь	2025 төл/2025 гүйцэт	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:			57,282.6	59,798.5	32,960.1	(24,322.5)	57.5	(26,838.4)	55.1
1	Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих	тонн	36,650.50	45,000.0	19,068.6	(17,581.9)	52.0	(25,931.4)	42.4
	Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах	тонн	17,990.00	10,611.0	13,891.5	(4,098.5)	77.2	3,280.5	130.9
	Газрын тосны бүтээгдэхүүний бөөний борлуулалт	тонн	2,642.10	4,187.5	-	2,642.1	-	(4,187.5)	-
2	Нийт орлого	м.төг	12,470,507.90	14,030,712.7	4,150,046.1	(8,320,461.8)	33.3	(9,880,666.6)	29.6
	Нийт зардал	м.төг	10,082,069.10	13,520,132.6	2,843,986.2	(7,238,082.9)	28.2	(10,676,146.4)	21.0
3	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	519,151.00	548,200.0	531,470.3	12,319.3	102.4	(16,729.7)	96.9
4	Татварын өмнөх ашиг	м.төг	2,388,438.80	510,580.1	1,306,059.9	(1,082,378.9)	54.7	795,479.8	255.8
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	2,138,904.00	459,522.1	1,171,720.7	(967,183.3)	54.8	712,198.6	255.0
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	1,040,801.20	959,951.90	879,282.80	(161,518.4)	84.5	(80,669.1)	91.6
	а/ Орлогын татварт	м.төг	207,140.10	51,058.0	76,431.4	(130,708.7)	36.9	25,373.4	149.7
	б/ НӨАТ	м.төг	386,884.20	392,771.2	301,141.5	(85,742.7)	77.8	(91,629.7)	76.7
	в/ НДШ	м.төг	319,053.00	370,432.2	343,330.2	24,277.2	107.6	(27,102.0)	92.7
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	115,471.70	132,890.5	145,361.4	29,889.7	125.9	12,470.9	109.4
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	9,357.40	10,500.0	8,889.6	(467.8)	95.0	(1,610.4)	84.7
	э/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	340.7	500.0	340.7	-	100.0	(159.3)	68.1
	ж/ Бусад тат варт	м.төг	2,554.10	1,800.0	3,788.0	1,233.9	148.3	1,988.0	210.4
7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг	347,186.10	976,776.6	1,069,452.0	722,265.9	308.0	92,675.4	109.5
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	35	38.0	33.0	(2.0)	94.3	(5.0)	86.8
9	Нийт цалингийн сан	м.төг	1,318,301.80	1,576,307.6	1,574,461.1	256,159.3	119.4	(1,846.5)	99.9
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	3,138.80	2,339.5	2,499.9	(638.9)	79.6	160.4	106.9
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	0.81	0.9	0.7	(0.1)	85.2	(0.3)	73.4
12	Хөрөнгө оруулалт	м.төг	238,269.00	432,962.0	279,106.7	40,837.7	117.1	(153,855.3)	64.5
13	Нийт авлага	м.төг	1,018,433.80	153,285.0	802,097.6	(216,336.2)	78.8	648,812.6	523.3
	Үүнээс: Найдваргүй	м.төг	-	-	-	-	-	-	-
14	Нийт өглөг	м.төг	338,279.7	157,285.0	211,680.6	(126,599.1)	62.6	54,395.6	134.6
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	315,236.50	4,000.0	199,181.0	(116,055.5)	63.2	195,181.0	4,979.5
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	23,043.20	153,285.0	12,499.6	(10,543.6)	54.2	(140,785.4)	8.2

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжийг газрын тосны бүтээгдэхүүний импортын хоёр дахь эх үүсвэр бий болгох зорилгоор Монгол Улсын Засгийн газраас Европын холбоотой хамтран ТАСИС хөтөлбөрийн хүрээнд буцалтгүй тусламжийн хөрөнгөөр барьж 2004 оны 04 дүгээр сард ашиглалтад оруулсан байна.

Энэхүү байгууламж нь орчин үеийн технологи, тоног төхөөрөмжөөр иж бүрэн хангагдсан, үйл ажиллагааны нэгдсэн систем бүхий Европын болон олон улсын сүүлийн үеийн стандартад нийцсэн Монгол Улсын анхны иж бүрэн газрын тосны байгууламж юм.

Байгууламжийн үндсэн үйл ажиллагаа нь БНХАУ-аас нарийн царигийн вагонцистернээр нийлүүлэгдэж байгаа газрын тосны бүтээгдэхүүнийг өргөн царигийн вагонцистернд шилжүүлэн ачих юм.

3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж нь 1999-2007 оны 08 дугаар сар хүртэл Замын-Үүдэд “Нефтийн бүтээгдэхүүн шилжүүлэн ачих байгууламжийн ашиглалтын өмнөх захиргаа” нэртэйгээр Сангийн Яамны мэдэлд үйл ажиллагаа явуулж байжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 196 дугаар тогтоолоор орон тоо, төсвийн хамт Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг АМГТХЭГ-ын /хуучин нэрээр/ харьяанд шилжүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 243, Төрийн өмчийн хорооны даргын 347 дугаар тогтоолоор АМГТХЭГ-ын харьяанд ажиллаж байсан уг байгууламжийг Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ болгон өөрчлөн баталсан.

Байгуулагдсан цагаасаа хойш үндсэн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж, өндөр үр ашигтай ажиллаж байсан ТӨҮГ-г Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 146 дугаар тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг нэгдсэн удирдлагаар хангах, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн тоог бууруулах, ашиг орлогыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Эрчис ойл ТӨХХК-д нэгтгэхээр шийдвэрлэж, үйлдвэрийн газрын үл хөдлөх болон бусад эд хөрөнгийг зохих журмын дагуу балансаас баланст, орон тооны хамт шилжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгаснаар 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон Эрчис ойл ТӨХХК-тай нэгтгэсэн.

Тайлант хугацаанд ТӨҮГ-ын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсноор зохион байгуулалтын хэлбэрээ өөрчилсөн байна.

Дотоод аудитын ажилтны чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын 2025 оны 10 дугаар сарын 31-нээрх санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж төрийн өмчит үйлдвэрийн газрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын захирлын 2024 оны А/26 дугаар тушаалаар шинэчлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2025 оны 10 дугаар сарын 31-нээрх санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн тэг болж Эрчис ойл ТӨХХК-тай нэгдсэн.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,583,513.8	-	(4,583,513.8)
Дансны авлага	707,809.8	-	(707,809.8)
Татвар, НДШ-ийн авлага	3,014.2	-	(3,014.2)
Бусад авлага	307,609.8	-	(307,609.8)
Бусад санхүүгийн хөрөнгө	6,080,877.6	-	(6,080,877.6)
Бараа материал	234,536.2	-	(234,536.2)
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	18,000.0	-	(18,000.0)
Үндсэн хөрөнгө	13,718,128.7	-	(13,718,128.7)
Хойшлогдсон татварын хөрөнгө	85,259.9	-	(85,259.9)
Нийт хөрөнгийн дүн	25,738,750.0	-	(25,738,750.0)
Богино хугацаат өглөг	-	-	-
Татварын өр төлбөр	5,162.7	-	(5,162.7)
Урьдчилж орсон орлого	306,163.8	-	(306,163.8)
Нөөц, өр төлбөр	3,910.0	-	(3,910.0)
Урт хугацаат өр төлбөр /Хойшлогдсон татварын өр/	23,043.2	-	(23,043.2)
Эздийн өмч	25,400,470.3	-	(25,400,470.3)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	25,738,750.0	-	(25,738,750.0)

Мөнгөн хөрөнгө, авлага, бусад санхүүгийн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, урьдчилж орсон орлого, эздийн өмч данстууд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

- **Мөнгөн хөрөнгө:** Тайлант хугацаанд мөнгөний үлдэгдэл 2,474.6 сая төгрөгөөр буурч, хугацаатай хадгаламжийн данс нээж бусад санхүүгийн хөрөнгө данс 3,118.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Эрчис ойл ХХК-д кассан дахь бэлэн мөнгө 2.7 сая төгрөг, 3 харилцах дансны үлдэгдэл 2,108.9 сая төгрөг, арилжааны банкнууд дахь хадгаламж 9,199.4 сая төгрөг, нийт 11,308.3 сая төгрөгийн шилжүүлэн өгсөн байна.
- **Дансны авлага:** Дансны авлагын үлдэгдэл 599.0 сая төгрөг болж 108.8 сая төгрөгөөр буурсан нь оны эхэнд Магнай трейд ХХК-с авах 244.7 сая төгрөгийн авлагыг барагдуулж, Лекс ойл ХХК-аас авах газрын тосны бүтээгдэхүүн хадгалалтын үйлчилгээний төлбөр хугацаандаа төлөгдөөгүйгээс алданги тооцсонтой холбоотой байна. Лекс ойл ХХК-тай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулан Эрчис ойл ХХК-д авлагын дансанд бүртгэлтэй 599.0 сая төгрөг татвар нийгмийн даатгалын авлага 9.5

сая төгрөг, бусад авлага 193.5 сая төгрөг, нийт 802.0 сая төгрөгийн авлага тус тус шилжүүлэн өгсөн.

- **Бусад авлага:** Өмнөх оны хадгаламжийн хүүгийн авлагуудыг барагдуулж, шинээр үүссэн хүүгийн авлагуудыг бүртгэж, тооцоо нийлж баталгаажуулсан.
- **Бараа материал:** Тайлант хугацаанд 142.6 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үйл ажиллагаанд 153.0 сая төгрөгийн материал зарцуулан ашиглалтын хэрэгцээ шаардлага хангахгүй болсон 87.8 сая төгрөгийн хангамжийн материалыг захирлын 2025 оны А/05, А/15, А/23 дугаар тушаалаар акталснаас үлдэгдэл 98.1 сая төгрөгөөр буурчээ. Эрчис ойл ХХК-д 136.4 сая төгрөгийн бараа материалыг балансаас балансад шилжүүлэн өгсөн.
- **Үндсэн хөрөнгө:** Тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу 202.4 сая төгрөгөөр албан тушаалын байр автомашины зогсоолын хамт, 19.5 сая төгрөгөөр засвар үйлчилгээ хийх байр, 20.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 0.6 сая төгрөгийн тавилга эд хогшил, 5.9 сая төгрөгийн зураг төсөв, нийт 248.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 71.9 сая төгрөгийн хөрөнгийг ангилал хооронд шилжүүлсэн болон капиталжуулалт хийж, ТӨБЗГ-ын 2025 оны 12 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 18 нэрийн 157.7 сая төгрөгийн хөрөнгийг 20.0 сая төгрөгөөр шинэчлэн үнэлсэн.

ТӨБЗГ-ын 2025 оны 278 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхөөгүй боловч ашиглалтын шаардлага хангахгүй 21 нэрийн 186.4 сая төгрөгийн балансын үнэ, 135.2 сая төгрөгийн хуримлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг, 2025 оны А1/1225 дугаар шийдвэрээр 3 нэрийн 18.3 сая төгрөгийн балансын үнэ, 9.6 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг тус тус акталж, 10.4 сая төгрөгийн хөрөнгийг ангилал хооронд шилжүүлж, 584.7 сая төгрөгийн элэгдэл байгуулснаар үндсэн хөрөнгийн нийт дүн 314.4 сая төгрөгөөр буурчээ.

Биет бус хөрөнгийн дансанд 612.4 сая төгрөгийн программ хангамж, 560.7 сая төгрөгийн газар эзэмших эрх, 54.5 сая төгрөгийн бусад биет бус хөрөнгө бүртгэлтэй.

МУЗГ-ын 2025 оны 146, ТӨБЗГ-ын 513 дугаар тогтоолоор Эрчис Ойл ТӨХХК-д 20,920.1 сая төгрөгийн балансын үнэ, 7,516.4 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн өгсөн.

- **Урьдчилж орсон орлого:** Арилжааны банкуудад байршуулсан хугацаатай хадгаламжийн хүүгийн өмнөх оны авлагыг бүртгэснийг тайлант онд орлогоор тайлагнаж, 2025 оны хүүгийн авлагыг бүртгэсэн байна. Эрчис Ойл ТӨХХК-д шатахууны картын үлдэгдэл 4.1 сая төгрөг, өр төлбөр дансны 205.6 сая төгрөгийн үлдэгдлийг тус тус балансаас балансад шилжүүлэн өгсөн.
- **Эздийн өмч:** Тайлант хугацаанд 2024 оны 2,138.9 сая төгрөгийн цэвэр ашгаас ТӨБЗГ-ын 2025 оны 312 дугаар тогтоолоор 1,069.5 сая төгрөгийн ногдол ашиг төвлөрүүлснээр өмчийн дүн 120.1 сая төгрөгөөр нэмэгдсэн.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын захирал нь байгууллагын эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ТӨБЗГ-ын 2024 оны 731 дүгээр тогтоолоор Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 14,030.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 13,520.1 сая төгрөгөөр, 510.6 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын 10 арга хэмжээнд 433.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 4,150.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,843.9 сая төгрөгийн зардал гарган, 1,306.1 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 4,150.0 сая төгрөг болж төлөвлөснөөс 8,320.5 сая төгрөг буюу 70.4 хувиар тасарсан нь Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж нь “Эрчис Ойл” ХХК-д нэгдэж үйл ажиллагаа явуулахаар болсон тул дээрх газрын тосны бүтээгдэхүүний бөөний борлуулалт хийгээгүй. Энэ нь борлуулалтын орлогын нийт дүн буурах үзүүлэлт болсон байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2,843.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 7,238.1 сая төгрөг буюу 79.0 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь борлуулалтын орлого биелээгүйгээс гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 9 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 279.1 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 1,171.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 712.2 сая төгрөгөөр илүү байгаа нь орлогын төлөвлөгөө биелээгүй боловч зардлыг хэмнэж ажилласан нь нөлөөлжээ.

ТӨБЗГ-т тайлант онд ногдол ашгийн 1,069.5 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

1. **Байгууллагуудын орон тооны цомхотголын талаар:** Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ нь 2025 онд орон тооны цомхотгол хийгээгүй. ТӨБЗГ-ын 2024 оны 731 дүгээр тогтоолоор 2025 оны бүтэц, орон тоог 41 байхаар 1,576.3 сая төгрөгийн цалингийн сан батлагдснаас 33 орон тоогоор ажиллаж 1,574.5 сая төгрөгийн цалингийн зардал гаргасан байна.
2. **Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар:** Тус байгууллага нь нэг хүний өдрийн хоолны зардлыг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/06 тоот захирлын тушаалаар 6,0 мянган төгрөгөөр баталсны дагуу 2025 онд 31.5 сая төгрөг зарцуулсан байна.
3. **Гадаад томилолт, арга хэмжээний талаар:** Тус байгууллага нь тайлант онд гадаад томилолтын зардал 8.0 сая төгрөгийн төсөв батлагдсан боловч зардал гараагүй байна.
4. **Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний талаар:** Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ нь 2025 онд сургалт, семинарт 6.1 сая төгрөг төлөвлөж 2.8 сая төгрөгийн зардал гарган 3 сургалт семинарт оролцсон байна.
5. **Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай ажил, үйлчилгээний гэрээ байгуулж ажиллаагүй байна.**

3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны 12,990.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 35 ажил төлөвлөснөөс 32 ажлын 694,6 сая төгрөгийн гэрээ байгуулж, 493.1 сая төгрөг зарцуулан

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж төрийн өмчит үйлдвэрийн газрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

201.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Төлөвлөгөөнөөс 7.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөргөлтийн системийн мэдрэгч худалдан авах ажлын гэрээ байгуулагдаагүй, 12,250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй өвөл, зуны дизелийн түлш худалдан авах тендер зарлагдаагүй байна.

2025 онд байгуулсан худалдан авалт, үйлчилгээний 15 гэрээний хугацаа дуусаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах санхүү, татварын тайлан мэдээллүүдийг хуулийн хугацаанд нь үнэн зөв тайлагнаж байх, үр дүнгийн шагналт цалинг жилийн эцсээр олгох, шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд иж бүрэн байршуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Аккурэйт финанс аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Бат-Эрдэнэ, аудитор Д.Сайнбаяр, Л.Баярмаа нар гүйцэтгэж, хяналтыг захирал Ж.Оюунбилэг анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор М.Ганбаатар, аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2025 оны 10 дугаар сарын 31-нээрх санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 01/148 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 13,208.4 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 132.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага ажлын ачааллыг нягтруулж, 5 орон тоо хэмнэж ажилласан байна. Цалингийн зардал 1,576.3 сая төгрөг батлагдсанаас 1,574.5 сая төгрөгийн цалингийн зардал гаргаж 1.8 сая төгрөг хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ нь Шилэн дансны цахим хуудсанд нийт 182 мэдээлэл байршуулахаас 178 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 4 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй, Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд, иж бүрэн, үнэн зөв байршуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Илрүүлэлт:

Ажилтнуудад 2025 оны жилийн эцсийн үр дүнгийн шагналыг хууль, журамд заасан хугацаанаас өмнө тооцож 9 дүгээр сард 279.8 сая төгрөг олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйл. 51.1.4 “улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох.”, Засгийн газрын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”, -ын 5.10 “Нэгжийн дарга албан хаагчийн төлөвлөгөөний эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлж баталгаажуулсан тайланг 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор, сүүлийн хагас жилийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлж баталгаажуулсан тайланг 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор үнэлгээний багт хүргүүлнэ”, хамтын гэрээний 2.12-т заасан “ байгууллагын жилийн эцсийн үр дүнг тухайн жилийн ашгаас хамаарч ... тухайн жилийн эцэст олгоно” гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үр дүнгийн шагналт цалин олгосон зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

Хамтын гэрээтэй холбоотой асуудал

2. Илрүүлэлт:

"Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨҮГ-ын 2022-2024 онд хэрэгжүүлэх хамтын гэрээ хугацаа дууссан.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 20.4. “Хамтын гэрээ, хамтын хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол түүний үйлчлэх хугацаа дуусахаас зургаан сараас илүүгүй хугацааны өмнө шинээр байгуулах хамтын гэрээ, хамтын хэлэлцээрийн талаар талууд санаачилга гаргаж болно.”, 31 дүгээр зүйл. Хамтын гэрээ, хамтын хэлэлцээр байгуулах 31.1. “Хамтын гэрээ, хамтын хэлэлцээрийг энэ хуулийн 18, 19, 20, 21, 22, 23, 24 дүгээр зүйлд заасан журмын дагуу байгуулна.” 60.1.4. хамтын хэлэлцээ хийх, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр байгуулах, гэснийг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Хөдөлмөрийн тухай хуулийг мөрдөж, хамтын гэрээ байгуулж ажиллах зөвлөмж өгсөн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, цалин хөлс, мөнгөн хөрөнгийн данснуудад горим, сорил хэрэгжүүлсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар, анхан шатны баримтын иж бүрдэлгүй баримтаар бараа, ажил үйлчилгээний төлбөрийг шилжүүлсэн, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд, иж бүрэн, үнэн зөв байршуулаагүй зөрчилд 2 зөвлөмж, газрын тосны бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээний үүргээ зөрчсөн, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчилд 2 албан шаардлага, Захирлын зөвлөлийн шийдвэргүйгээр шагнал олгосон, томилолтын хугацаанд хоолны мөнгө олгосон зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосныг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Төлбөрийн акт	2	3,168.0	2	3,168.0	100.0
2	Албан шаардлага	2	-	2	-	100.0
3	Зөвлөмж	2	-	2	-	100.0
	Нийт дүн	6	3,168.0	6	3,168.0	100.0

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн зөрчилд 3.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 2 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Газрын тосны салбар үүсэж хөгжсөний 84 жилийн ойн хүрээнд байгууллагуудын хооронд зохион байгуулагдсан "Спорт 7 төрөлт" тэмцээний зардал 3.6 сая төгрөг гаргасан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг 20.2.4. "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасныг хэрэгжүүлээгүй.

Шийдвэрлэсэн нь: Тэмцээний зардал гаргасан зөрчилд буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Татварын тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд татварын цахим системд татварын тайлангуудыг 25 удаа засварлан илгээсэн байна. Үүнд 2024 оны ААНОАТ тайланг 2025 оны 12 сарын 15-нд, мөн НӨАТ-ын 2024 оны 1 сараас 12 сарын тайлангуудыг дахин засварлан илгээсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хууль 16 дугаар зүйл: 16.5.7. "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг 20.2.3. "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4. "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэнтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хуулийн хугацааг мөрдөж санхүү, татварын тайлан, мэдээг үнэн, зөв гаргаж тайлагнаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**6.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Газрын тосны салбар үүсэж хөгжсөн 84 жилийн ойн хүрээнд байгууллагуудын хооронд зохион байгуулагдсан "Спорт 7 төрөлт" тэмцээний зардал 3,630.0 гаргасан байна.	1	3,630.0	1	3,630.0	-	-	-	-	-	-	-	-
2	Тайлант онд татварын цахим сайтад татварын тайлангуудыг 25 удаа засварлан илгээсэн байна. Үүнд 2024 оны ААНОАТ тайланг 2025 оны 12 сарын 15 нд, 2024 оны 1-12 сар тайлангуудыг дахин засварлан илгээсэн байна.	1	-					1	-			-	-
	Дүн	2	3,630.0	1	3,630.0	-	-	1	-	-	-	-	-

6.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
1	Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 182 мэдээллийг ил тод байршуулахаас 178 мэдээллийг байршуулж, 4 мэдээллийг хугацаа хоцроосон байна.	1	-	-	-	1	-	-	-
	Дүн	1	-	-	-	1	-	-	-
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
1	"Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨҮГ-ын 2022-2024 онд хэрэгжүүлэх хамтын гэрээний хугацаа дууссан.	1	-	-	-	-	-	1	-
2	2025 оны жилийн эцсийн үр дүнгийн шагналыг 9 дүгээр сард олгосон байна.	1	279,854.6	-	-	1	279,854.6	-	-
	Дүн	1	279,854.6	-	-	1	279,854.6		
	Нийт дүн	3	279,854.6	-	-	2	279,854.6	1	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 177/A0150053

Улаанбаатар хот

САГ-2026/88/ИА-СТА-ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Газрын тосны салбар үүсэж хөгжсөний 84 жилийн ойн хүрээнд байгууллагуудын хооронд зохион байгуулагдсан "Спорт 7 төрөлт" тэмцээний зардал 3,630,000.00 /гурван сая зургаан зуун гучин мянган/ төгрөгийг шилжүүлж, зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах." /Энэ заалтыг 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн./, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8 "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн"-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулахад зарцуулсан 3,630,000.00 /гурван сая зургаан зуун гучин мянган/ төгрөгийг шийдвэр гаргасан захирал Г.Гансүхээр төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын захирал /Г.Гансүх/, ерөнхий нягтлан бодогч /Б.Долгордалай/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АККУРЭЙТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ж.ОЮУНБИЛЭГ

9006109
ATA16097
9025091411

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Ак\2026\0316.SAG-31.Docx

1526200237



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 826/A0150053

Улаанбаатар хот

САГ - 2026/88/КА - СТА - ТӨҮГ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны жилийн эцсийн үр дүнгийн шагналыг хууль, журамд заасан хугацаанаас өмнө тооцож 279,854,578.00 /хоёр зуун далан есөн сая найман зуун тавин дөрвөн мянга таван зуун далан найман/ төгрөгийг 9 дүгээр сард олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 20 дугаар зүйл 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төрийн өмчит үйлдвэрийн газрын 2022-2024 онд хэрэгжүүлэх хамтын гэрээний 2.12-т Байгууллагын жилийн эцсийн ажлын үр дүнг харгалзан тухайн жилийн ашгаас хамаарч ажилтанд жилийн ажлын үр дүнг ... нэмэгдлийг тухайн жилийн эцэст олгоно.", Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолын хавсралт "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлэх журам", гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үр дүнгийн шагналыг хууль, журамд заасан хугацаанаас өмнө тооцож олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын захирал /Г.Гансүх/, ерөнхий нягтлан бодогч /Б.Дэлгэрдалай/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АККУРЭЙТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Ж.ОЮУНБИЛЭГ

9006109
ATA16087
9025081411



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 827/А0150053

Улаанбаатар хот

САГ-2026/88/НА-СТА-ТӨҮГ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 182 мэдээллийг ил тод байршуулахаас 178 мэдээллийг байршуулж, 4 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэлчүүнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, албан шаардлагын биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын захирал /Г.Гансүх/, ерөнхий нягтлан бодогч /Б.Дэлгэрдалай/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР,
АУДИТЫН МЕНЕЖЕР,
АККУРЭЙТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Ж.ОЮУНБИЛЭГ

